



## БҮЛЭГ 3: “ХУВЬ ХҮН БА ЭДИЙН ЗАСАГ”

Сэдэв:

ОРОН НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН БҮТЦИЙН ТАЛААР БИД  
ЮУ МЭДЭХ ВЭ?

Хамрах хүрээ: 8 анги

УЛААНБААТАР  
2021

Багш: З. Цэвэгмиджав

## СЭДВИЙН ЗОРИЛГО:

---

- ❑ Орон нутгийн эдийн засаг гэж юуг хэлдэг, хүмүүс баялагийг хэрхэн бүтээдэг тухай ойлголттой болох
- ❑ Түүнийг танин мэдсэнээрээ түүнд оруулах өөрийн хувь нэмрийг тодорхойлох, хэрэгжүүлэх чадвар эзэмшинэ.

# ОРОН НУТГИЙН ЭДИЙН ЗАСАГ ГЭЖ ЮУ ВЭ?

Орон нутаг гэдэг нь газарзүйн байршил төдийгүй эрх мэдэл, түүний хүрээ хязгаарыг илэрхийлдэг ойлголт юм.

Орон нутгийн эдийн засаг гэдэг нь тухайн орон нутгийн хүн ам, баялаг бүтээх, орон нутгаа хөгжүүлэх тухай багц асуудлыг багтаана.



## Үүнд:

- ❑ Хүн ам, эдийн засгийн бүтэц, аж ахуй эрхлэлт
- ❑ Засаг захиргааны болон нийгмийн үйлчилгээний байгууллагуудын хэлбэр
- ❑ Орон нутгийн зах зээлийн харилцаа
- ❑ Орон нутгийн төсвийн орлого, зарлагын асуудал орно.



Монгол улсын үндсэн хуульд: Нутгийн өөрөө удирдах байгууллага нь тухайн орон нутгийнхаа эдийн засаг, нийгмийн амьдралыг бие даан шийдвэрлэх ба уг асуудлыг шийдвэрлэхдээ хүн амыг зохион байгуулж оролцоно.

Хүн амын орон нутагт тархан суурьшсан байдал нь орон нутгийн эдийн засагт чухал нөлөөтэй.



- Хүн амын бөөгнөрөл хот суурин газарт их байхад хөдөө орон нутагт бага байна. Хүн амын тоо ихсэх тусам эдийн засгийн бүтэц томордог.



---

Тухайн орон нутагт эдийн засгийн үйл ажиллагаа буй аж ахуй нэгж байгууллага, иргэд **баялагийг бий болгодог**. Баялгийг бүтээж байгаа салбараар нь:

- ❑ Аж үйлдвэр, барилга
- ❑ Хөдөө аж ахуй
- ❑ Худалдаа үйлчилгээ
- ❑ Бусад

# АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГА ДАРААХ ХЭЛБЭРЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ.

1. Үйлдвэрлэл: Хэрэглэгчдийн хэрэгцээг хангах чадвартай материаллаг биет зүйлс үйлдвэрлэн гаргах
2. Худалдаа: Төрөл бүрийн бараа худалдан авч, хадгалах, тээвэрлэх, худалдах үйл явц
3. Үйлчилгээ: Хүмүүсийн хэрэгцээг хангах зорилготой бодит бус шинжтэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд орно. ( сургууль, эмнэлэг, үсчин, зурагчин, төрөл бүүрийн засвар үйлчилгээ...)



Орон нутгийн эдийн засаг гэдэг нь аймаг нийслэл, сум дүүрэг, баг хорооны нутаг дэвсгэр дэх хүн ам, аж ахуй эрхлэлт, эдийн засгийн бүтэц, зах зээлийн харилцаа, орон нутгийн орлоготой холбоотой багц асуудлыг багтааж үздэг.

# БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ

Байгууллагын үйл ажиллагааны онцлогоор нь гурав ангилж үздэг.

1. **Төрийн байгууллага-** Төрийн үйл ажиллагааг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг орон нутгийн иргэдэд хүргэж байдаг, төсвөөс санхүүждэг байгууллагууд.

---

**2. Төрийн бус байгууллага-** Өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр нэгдэн үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллага

**3. Аж ахуй нэгж-** Улсын бүртгэлд бүртгэгдэж, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагууд орно. Тэдний зорилго нь ашиг олоход оршино.



## СЭДВИЙН БАТАТГАЛ

---

Эх сурвалжтай ажиллаж асуултанд хариулна.

Сурах бичиг хуудас: 46-47

---

Гэрийн даалгаварт: Танай орон нутагт хамгийн олон бүтээгдэхүүн үйлдвэрлэж нийлүүлдэг ААН аль нь вэ? Мэдээлэл бэлтгээрэй.